

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ATA11169 8448906
9023111371

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1		
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1		
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5		
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5		
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5		
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5		
Хэсгийн оноо				4		
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1		
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1		
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1		
Хэсгийн оноо				3		
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1		
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)		1		
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1		
Хэсгийн оноо				3		
Үнэлгээний нийт оноо, хувь				10		

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

- [1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
- [2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
- [3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".
- [4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн баталсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.
- [5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.
- [6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.
- [7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
- [8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.
- [9] ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.
- [10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
- [11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
- [12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
- [13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.
- [14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
- [15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.